



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

“Төлөөлөгчийн нэг өдөр” өдөрлөг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2015 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Иргэд сонгогчдод Нутгийн өөрөө удирдах байгууллагын хийж хэрэгжүүлж буй ажлыг сурталчилах, Төлөөлөгч-иргэдийн хамтын ажиллагааг дээшлүүлэх, иргэдийн санал хүсэлтийг авч шийдвэрлэх, төрийн үйлчилгээг шуурхай хүргэх зорилго бүхий “Төлөөлөгчийн нэг өдөр” өдөрлөгийг хороодод зохион байгуулахыг Хурлын ажлын алба /Ц.Алтанцацрал/-нд үүрэг болгосугай.

2. Өдөрлөгийн удирдамж, хөтөлбөрийг төлөөлөгчдийн саналыг тусган тухай бүр батлан ажиллахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-нд үүрэг болгосугай.

3. Өдөрлөгийн арга хэмжээний бэлтгэлийг ханган, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс албадтай хамтран зохион байгуулж, үр дүнг тухай бүр танилцуулахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

**Иргэдийн оролцоог идэвхжүүлэх
ажлыг эрчимжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Хууль тогтоомж, Улсын Их Хурал, Засгийн газар, Нийслэл, дүүргийн Хурал, Тэргүүлэгчдээс баталсан шийдвэр, бодлого, зорилт, үйл ажиллагааг иргэдэд шуурхай хүргэх, сурталчилах, Төрийн үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгох, чанар хүртээмжийг нь сайжруулах, иргэдээс тавьсан санал, хүсэлтийг хүлээн авч, судлан шийдвэрлэх, мэдээ, мэдээллээр хангах замаар Төрийн бодлого, үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах ажлыг эрчимжүүлэхийг Хурлын ажлын алба /Ц.Алтанцацрал/-нд даалгасугай.

2. Цаг үеийн болон бусад шаардлагатай мэдээ, мэдээллээр иргэдэд зориулсан ном, гарын авлага, хэвлэмэл хуудас зэргийг хэвлүүлэн хүргэж байхыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/, Засаг даргын Тамгын газар /Ж.Эрдэнэбат/ нарт даалгасугай.

3. Иргэдийн оролцоог идэвхжүүлэх арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны тайланг хагас, бүтэн жилээр Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-нд үүрэг болгосугай.

ДАРГА  Д.БАТ-ЭРДЭНЭ





ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Зөвлөлдөх уулзалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2015 онд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэх иргэдийн бүлгүүдийн зөвлөлдөх уулзалт зохион байгуулахыг Хурлын ажлын алба /Ц.Алтанцацрал/-нд даалгасугай.

2. Уулзалтын удирдамжийг нэгдүгээр, уулзалтын хөтөлбөрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Уулзалт зохион байгуулахад шаардагдах зардлыг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-нд зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 02 дугаар сарын 09-ний
өдрийн 11 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт



ДҮҮРГИЙН “ИРГЭДИЙН БҮЛЭГ”-ИЙН ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТЫН УДИРДАМЖ

Зорилго: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2015 онд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэх талаар иргэдийн бүлгүүдийг мэдээллээр хангах, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлд орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд оршино.

Хугацаа: 2015 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 13⁰⁰ цагт “Бишрэлт” рестораны Хурлын танхимд зохион байгуулна.

Хамрах хүрээ: Чингэлтэй дүүргийн 1-19 дүгээр хороонд байгуулагдсан иргэдийн бүлэг

Хамтран зохион байгуулагч: Дүүргийн Засаг даргын Санхүү Төрийн сангийн хэлтэс, Засаг даргын дэргэдэх Худалдан авах ажиллагааны алба, “Тогтвортой амьдрах итгэл” ТББ

Зохион байгуулалт: Дүүрэг, хорооны судалгаанд бүртгэлтэй иргэдийн бүлгүүдэд иргэдийн бүлгийн ойлголт, ач холбогдол, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаанд бүлгүүдийн оролцоог хангах, иргэдийн тав тухтай орчныг бүрдүүлэхэд иргэдийн бүлгүүдийн оролцооны талаарх сургалт, уулзалт зөвлөгөөнийг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна.

Үр дүн: Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2015 онд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэхэд иргэдийн бүлгүүдийн оролцоог хангах, энэ чиглэлийн мэдлэг мэдээлэл олгох замаар бүлгүүдийн үйл ажиллагааг чадавхжуулна.

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 02 дугаар сарын 09-ний
өдрийн 11 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт



ДҮҮРГИЙН “ИРГЭДИЙН БҮЛЭГ”-ИЙН
ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТЫН ХӨТӨЛБӨР

Уулзалт: 2015 оны 02 дугаар сарын 13-ны 13⁰⁰ цагт “Бишрэлт” рестораны
хурлын танхимд зохион байгуулагдана.

- | | |
|------------------------------------|--|
| 12 ⁵⁰ -13 ⁰⁰ | Бүртгэл |
| 13 ⁰⁰ -13 ¹⁰ | Нээлт /Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Д.Бат-Эрдэнэ/ |
| 13 ¹⁰ -14 ⁰⁰ | Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаа, иргэдийн бүлгийг бүртгэх, жишиг баримт бичиг бүрдүүлэх заавар

/Дүүргийн Засаг даргын дэргэдэх Худалдан авах ажиллагааны албаны дарга С.Жамъяндорж/ |
| 14 ⁰⁰ -14 ²⁰ | Иргэдийн бүлгээр хийгдсэн ажлын санхүүжилт түүнийг олгоход бүрдүүлэх баримт бичиг, анхаарах зүйлс

/Дүүргийн Засаг даргын Санхүү, Төрийн сангийн хэлтсийн Төсвийн мэргэжилтэн Г.Чинсанаа/ |
| 14 ²⁰ -15 ⁰⁰ | Иргэдийн үүсгэл санаачлагын бүлэгт гишүүдийн оролцоо, бүлгийн хөгжлийг дэмжих арга зүй

/“Тогтвортой амьдрах итгэл” ТББ-ын тэргүүн Г.Энхтуяа/ |
| 15 ⁰⁰ -15 ²⁰ | Иргэдийн бүлгээр хийсэн ажлын сайн туршлагаас

/17 дугаар хорооны “Бүтээлч үйлс” иргэдийн бүлгийн ахлагч Л.Дашдорж/ |
| 15 ²⁰ -16 ⁰⁰ | Асуулт, хариулт |

Жич: Зөвлөлдөх уулзалтанд хамрагдсан иргэдийн бүлгүүдийг ном, гарын авлагаар хангана.



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Соёл, урлагийн төлбөрт үйлчилгээний
журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Соёл, урлагийн төлбөрт үйлчилгээний журмыг нэгдүгээр, соёл урлагийн төлбөрт үйлчилгээний хураамжийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 02 сарын 09-ний
өдрийн 12 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



Соёл, урлагийн төлбөрт үйлчилгээний журам

Нэг. Нийтлэг зүйл

Энэхүү журмын зорилго нь дүүргийн хэмжээнд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд соёл, урлагийн төлбөрт үйлчилгээг эрхлэн явуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Соёл, урлагийн төлбөрт үйлчилгээнд хамрагдах төрлүүд

- 2.1. Соёлын төвд явагдах дугуйлан, сургалтууд
- 2.2. Урлагийн тоглолт
- 2.3. Танхим ашиглалтын үйлчилгээ
- 2.4. Хувцас түрээсийн үйлчилгээ
- 2.5. Хөгжим, техник аппаратурын үйлчилгээ

Гурав. Соёл, урлагийн төлбөрт үйлчилгээ, зохион байгуулахад тавигдах шаардлага

- 3.1. Соёл, урлагийн мэргэжлийн төлбөрт дугуйлан, сургалтууд
 - 3.1.1. Дугуйлан, сургалтын хичээлийг мэргэжлийн багш нар заана.
 - 3.1.2. Сургалтын хөтөлбөртэй байна.
- 3.2. Урлаг, уран сайхны хамтлаг, чуулга, уран бүтээлчдийн тоглолт
 - 3.2.1. Урлагийн хамтлаг, уран бүтээлчдийн тоглолтыг зохих техник хэрэгсэл, тоног төхөөрөмж бүхий зориулалтын байранд, шаардлагатай хөгжмийн зэмсэг, хувцас, хэрэглэгдэхүүнтэй зохион байгуулна.
- 3.3. Танхим ашиглалтын үйлчилгээ
 - 3.3.1. Танхимыг урлагийн тоглолт, хурал, уралдаан тэмцээн болон үндсэн үйл ажиллагааны дагуу түрээслүүлэн ашиглуулна.
- 3.4. Хувцас түрээсийн үйлчилгээ
 - 3.4.1. Урлагийн тоглолтын хувцас болон жижиг хэрэглэгдэхүүнийг зориулалтын дагуу түрээслүүлэн ашиглуулна.
- 3.5. Хөгжим, техник хэрэгслийн үйлчилгээ
 - 3.5.1. Дууны болон хөгжмийн техник хэрэгслийн зориулалтын дагуу иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад түрээслүүлэн ашиглуулна.

Дөрөв. Соёлын төвийн эрх, үүрэг.

- 4.1. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлтийг судлах, тэдгээрт төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэх, хамтын ажиллагааг сайжруулна.
- 4.2. Энэхүү журмын хүрээнд иргэд, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж ажиллана.
- 4.3. Түрээс, сургалтын төлбөрийн орлогын 20%-ийг үндсэн болон гэрээт багшийн урамшуулалд, 30%-ийг хувцас, хэрэглэгдэхүүний цэвэрлэгээ

үйлчилгээ, сургалтын багаж хэрэгслийн шинэчлэлтэд, 50%-ийг төсөвт төвлөрүүлэн ажиллана.

4.4. Сургалт, дугуйланд идэвхтэй хамрагдаж дүүрэг, нийслэл, улсын уралдаанаас шагнал авсан, нэн ядуу амьдралтай өрхийн хүүхдэд сургалтын төлбөрөөс 30%-100% хүртэл хөнгөлөлт үзүүлнэ. Үүнд:

- Амьжиргааны түвшингээс доогуур орлоготой өрхийн хүүхдэд - 30%,
- Хагас өнчин хүүхэд - 50%,
- Бүтэн өнчин хүүхэд - 100%-ийн хөнгөлөлт эдэлнэ.

Энэхүү төлбөрийн хөнгөлөлт нь жилд 50 хүртэл хүүхэд хамрагдах ба хороо, дүүргийн Засаг даргын тодорхойлолтыг үндэслэнэ.

4.5. Энэ журмын дагуу үйл ажиллагааг зохион байгуулна.

Тав. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн эрх, үүрэг

5.1. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд энэхүү журмын хүрээнд гэрээ байгуулан ажиллана.

- Гэрээ байгуулахдаа аж ахуйн нэгж, байгууллага бол албан хүсэлт, иргэн бол иргэний үнэмлэхний хуулбарыг хүсэлтийн хамт ирүүлнэ.
- Төлбөрийг тухайн үйл ажиллагаа явуулахаас 3 хоногийн өмнө хийж дуусгах ба урьдчилгаа 30%-ийг гэрээ байгуулснаас хойш 1 хоногийн дотор төлсөн байна.

5.2. Хөгжим техник аппаратур, хувцас хэрэглэгдэхүүнийг гадуур хэрэглэх тохиолдолд түрээслэгч байгууллага зөөвөрлөх унааг хариуцна.

5.3. Сургалт, дугуйланд хамрагдсан иргэд нь дүүргийн хэмжээний уралдаан тэмцээнд амжилт үзүүлсэн тохиолдолд 30%, нийслэлийн хэмжээний уралдаан тэмцээнд амжилт үзүүлсэн тохиолдолд 50%, олон улсын уралдаан тэмцээнд амжилт үзүүлсэн тохиолдолд 100% төлбөрийн хөнгөлөлт эдэлнэ.

5.4. Энэхүү журмын 4.4 дүгээр зүйлд заасан сургалтын төлбөрийн хөнгөлөлт эдлэх иргэн нь жил бүрийн 1 дүгээр сард багтаан өргөдөл, хүсэлт гаргаснаар төлбөрийн хөнгөлөлт эдэлнэ.

5.5. Дүүргийн нутаг дэвсгэрт амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь дугуйлан, сургалтанд үнэ төлбөргүй хамрагдана.

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 02 сарын 09-ний
өдрийн 12 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



Соёл, урлагийн төлбөрт үйлчилгээний хураамж

№	Үйлчилгээний төрөл зүйл	Хугацаа	Үйлчилгээний хураамж /мян.төг/	Тайлбар
1	Дугуйлан, сургалтанд суралцагчийн төлбөр	1 сард	20000	
2	Танхим ашиглалтын үйлчилгээ /танхим, хөгжим аппаратур, техникийн ажилтан, тог цахилгаан/	1 цагт	50000	
3	Хувцас түрээсийн үйлчилгээ /1 иж бүрэн хувцас/	1 өдөр	20000	
4	Хөгжмийн түрээс /морин хуур, хөгжмийн зэмсэг гэх мэт/	1 өдөр	30000	
5	Техник, аппаратурын үйлчилгээ /2 чанга яригч бүхий бага хэмжээний иж бүрдэл/	1 удаагийн арга хэмжээ /2 цаг хүртэл/	50000	Үндсэн цагаас илүү гарсан 1 цаг тутамд 20.000₮ нэмэгдэж тооцно.
6	Техник, аппаратурын үйлчилгээ /4 яригч бүхий иж бүрдэл/	1 удаагийн арга хэмжээ /2 цаг хүртэл/	100000	



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд
иргэдийг оролцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4 дэх заалтыг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд АЗ гэрчилгээ бүхий хавсралтад нэр дурьдсан иргэдийг оролцуулахаар шийдвэрлэсүгэй.
2. Дүүргийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд хавсралтад дурьдсан иргэдийг оролцуулж, Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д даалгасугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-нд үүрэг болгосугай.

ДАРГА  Д.БАТ-ЭРДЭНЭ



Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 02 сарын 09-ний
өдрийн 13 дугаар тогтоолын хавсралт



Дүүргийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд
томилогдон ажиллах иргэдийн нэрсийн жагсаалт

№	Хороо	Овог, нэр	Оршин суугаа хаяг	Мэргэжил	Одоо эрхлэж буй ажил	Утасны дугаар
1	2	Д.Эрдэнэтуяа	40 мянгатын 23-35	Инженер, санхүүч, ня-бо	ТББ-д ажилладаг	96050817
2	4	Б.Эрдэнэцогт	Бага тойруу 21-2	Инженер	ТҮК-ийн цэцэрлэгч	99186753
3	5	Э.Өлзийжаргал	18-29	Хүний нөөцийн менежер	5-р хорооны 3-р хэсгийн ахлагч	88838881 88800818
4	6	Ч.Жадамба	52-10	Эрх зүйч	Тэтгэвэрт	91156170
5	8	Л.Ган-Өлзий	Зүүн тасаг 7-114	Нягтлан бодогч	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	99186181
6	9	Л.Лувсанцэрэн	Дэнжийн 1-126	Эдийн засагч	Монгол хьундай автмотив, эдийн засагч	99905523
7	10	Э.Бадамгарав	Дэнжийн 30-380	Эдийн засагч	Дүүргийн ИТХ-д ажилладаг	99246030
8		Б.Мөнхшүр	40-565	Багш	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	94080825
9	12	Б.Болор	Булгын 16-681	Төрийн захиргааны Удирдлага	Дүүргийн БИТ-д ажилладаг	99277317
10	13	М.Мөнхтөр	Сургуулийн 37-741	Эдийн засагч, барилгын инженер	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	99022151
11		Е.Рэнцэнноров	Сургуулийн 37-741а	Эдийн засагч	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	99146602
12		Д.Уранчимэг	Сурагчийн 5-67	Нягтлан бодогч	Нягтлан бодогч	96378000
13	15	Д.Батболд	Жаргалантын 31-516б	Малын эмч	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	91187872
14	17	Б.Ундрэм	Сурагчийн 49-1-6	Нягтлан бодогч	Био бодис ХХК	88889778
15	19	Т.Энхбаяр	Дээд салхитын 26-403а	Нягтлан бодогч	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	91116659
16		Ш.Амгалан	Дээд салхитын 5-98	Барилгын инженер	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	96461560



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд Засаг даргын Тамгын газрын Эрх зүйн сургалт, тогтоол шийвдэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн /Л.Ариунзаяа/-г нэмж баталсугай.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлж, тэдний бүтээлч идэвх санаачлагыг өрнүүлэх зорилго бүхий “Ахмад настанд ээлтэй байгууллага, иргэн”-ийг шалгаруулах журмыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү журмыг аж ахуй нэгж байгууллага, иргэдэд сурталчилж, харъяалах байгууллагагүй болсон ахмадуудыг аж ахуй нэгж байгууллагад харъяалуулах ажлыг зохион байгуулахыг дүүргийн Засаг дарга /Д.Ганболд/-д даалгасугай.

3. Журам шинэчлэн баталсантай холбогдуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2001 оны 100 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАТ-ЭРДЭНЭ



Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 02 дугаар сарын
09-ний өдрийн 15 дугаар тогтоолын хавсралт



Ахмад настанд ээлтэй байгууллага, иргэн шалгаруулах журам

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Ахмад настны талаар баримтлах төрийн бодлого, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага /цаашид байгууллага гэх/, иргэдээс ахмад настанд үзүүлэх анхаарал халамжийг нэмэгдүүлэх, тэдний бүтээлч идэвх санаачлагыг өрнүүлэх зорилгоор ахмад настанд ээлтэй байгууллага, иргэнийг шалгаруулна.

1.2. Доорх болзлыг хангасан аж ахуйн нэгж байгууллагын талаар хорооны Иргэдийн Нийтийн Хурлын дарга, Засаг дарга, Ахмадын зөвлөл хамтран гаргасан тодорхойлолтыг жил бүрийн 09 дүгээр сарын 01-ний дотор дүүргийн Ахмадын байгууллага хүлээн авна.

1.3. Ахмад настанд ээлтэй байгууллага, иргэнээр жилд тус бүр 3-аас илүүгүй байгууллага, иргэнийг шалгаруулна.

ХОЁР. Шалгаруулах болзол

2.1. Аж ахуйн нэгж, байгууллага

2.1.1. Оршин байрлаж, үйл ажиллагаа явуулж байгаа Нутгийн удирдлага болон ахмадын байгууллагатай байнга хамтран ажиллаж бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлдэг байх.

2.1.2. Ажиллаж байсан байгууллага нь татан буугдсан эсвэл шилжин ирсний улмаас харъяалан туслах байгууллагагүй болсон дүүргийн Ахмадын хороонд бүртгэлтэй 3-аас доошгүй ахмад настныг хорооныхоо Засаг даргатай гэрээлэн байгууллага өөрийн өндөр настны бүртгэлд бүргэж зохих дэмжлэг туслалцаа үзүүлдэг байх.

2.1.3. Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн хөдөлмөрийн чадвартай нэгээс доошгүй ахмадыг байнгын ажил хөдөлмөртэй болгож, цалинжуулсан байх.

2.1.4. Өрхийн үйлдвэрлэл эрхэлдэг ахмад настныг дэмжин бүтээгдхүүнийг нь борлуулах буюу сурталчилсан байх.

2.1.5. Тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үйлчилгээнд ахмад настныг дараалалгүй буюу тэргүүн ээлжинд үйлчлэх зэрэг журмыг тогтоож мөрдөж хэвшсэн байх.

2.1.6. Ахмад настныг идэвхтэй, эрүүл, урт наслах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, амьдралын баталгааг дээшлүүлэх талаар бүтээлч, санаачлагатай оролцож, тэдний дунд зохион байгуулсан соёл урлаг, эрүүл мэнд, спортын арга хэмжээнд зохих дэмжлэг туслалцаа үзүүлдэг байх.

2.1.7. Ахмад настанд тусламж үзүүлэх, асран халамжлах сайн дурын үйл ажиллагаа болон ахмадуудын бүтээлч, идэвхтэй амьдралын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилдаг байх.

2.2. Иргэн

2.2.1. Ахмад настанд сэтгэл санааны болон эд материалын дэмжлэг үзүүлж, орон нутгийн засаг захиргаа, ахмадын байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог байх.

2.2.2. Асран хамгаалах, харгалзан дэмжих үр хүүхэд, ах дүү, төрөл садангүй ганц бие буюу нэн ядуу ахмад настныг өөрийн байнгын ивээл халамжиндаа өргөн тэтгэдэг байх.

2.2.3. Ахмад болон залуу үед бүтээлч, идэвхтэй, эрүүл аж төрөх үлгэр дууриалал үзүүлж, буй ахмад настан байх.

ГУРАВ. Шалгаруулах журам

3.1. Энэ журмын 2 дахь хэсэгт заасан болзлыг бүрэн хангасан тухай тодорхойлолтыг зохих журмаар байгуулагдсан ажлын хэсэг жил бүрийн 09 дүгээр сарын 10-ны дотор газар дээр нь шалган танилцаж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар 09 дүгээр сарын 25-ны дотор хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

3.2. Ахмад настанд ээлтэй байгууллага, иргэнийг Иргэдийн шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд дүүргийн Иргэдийн Хурлын Төлөөлөгч, Хурлын Ажлын албаны ажилтан, Ахмадын хорооны дарга, Засаг даргын Тамгын газрын төлөөлөл орно.

ДӨРӨВ. Шагнал

4.1. Шалгарсан байгууллага, иргэнийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт өргөмжлөл”-ийн хамт байгууллага тус бүрийг 500000 хүртэл төгрөгөөр, иргэн тус бүрийг 250000 хүртэл төгрөгөөр шагнаж урамшуулна.

4.2. Шагналыг жил бүрийн 10 дугаар сарын 01-ний Нийтээр тэмдэглэх тэмдэглэлт Ахмадын өдрийг тохиолдуулан шагнаж урамшуулж хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

┌ **Ахмад настанд хүндэтгэл үзүүлэх тухай** ┐

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Арван долоодугаар жарны хөхөгчин хонин жилийн сар шинийн баярыг тохиолдуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас өндөр настны тэтгэвэрт гарсан болон хороодын Иргэдийн Нийтийн Хуралд ажиллаж байгаа ахмадуудыг 2015 оны 02 дугаар сарын 15-ны өдөр хүлээн авч, хүндэтгэл үзүүлсүгэй.

2. Ахмадуудад хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааны бэлтгэл зохион байгуулалтыг хангаж ажиллахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

3. Шаардагдах зардлыг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

Буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дахь заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дүрмийн 2.19 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч Д.Ядамжав нь бүл нэмж шинээр хүүхэдтэй болсон тул нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж олгохоор шийдвэрлэсүгэй.

2. Шаардагдах зардлыг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-нд зөвшөөрсүгэй.

ДАРГА  Д.БАТ-ЭРДЭНЭ



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

Шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 165 дугаар тогтоолыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж, эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажиллаж байгаа хавсралтад нэр дурдсан иргэдийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналаар шагнасугай.
2. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Чандмань одонгоор шагнагдах иргэдийн нэрсийг нэгдүгээр, Хурлын Хүндэт өргөмжлөлөөр шагнагдах иргэдийн нэрсийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Шагналд шаардагдах зардлыг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 02 сарын 09-ний
өдрийн 18 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



“Чандмань одон”-гоор шагнагдах хүмүүсийн нэрс

Д/д	Овог нэрс	Эрхэлсэн ажил, мэргэжил	Регистрийн дугаар
1.	Ч.Самдан	Түвдэнпэлжээлин хийдийн Гэсгүй лам	ИЭ80102490
2.	С.Бямбаа	Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны Иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгч	ЖЯ51072701
3.	Ж.Булганцэцэг	Чингэлтэй дүүргийн 15 дугаар хорооны Иргэдийн Хурлын дарга	АМ83031106
4.	А.Норжинсүрэн	Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны иргэн	ХН43060507
5.	Б.Эрдэнэчимэг	Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны МАХН-ын 17 дугаар үүрийн дарга	ЧО53021703
6.	Ш.Үвдэлмаа	Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны ахмад настан	ХИ44102061
7.	Т.Цэцэгжаргал	Улаанбаатар төмөр замын Баянбуурал амралтын жижүүр	НБ77062502
8.	Ү.Пүрэвсамбуу	Соёлын сургуулийн аж ахуйн дарга	ЧИ48022518
9.	Л.Энхцэцэг	Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хорооны иргэн	НО64122269
10.	Д.Батлхам	“Замчдын хотхон” СӨХ-ны ашиглалтын байцаагч	РЮ62122709
11.	Д.Содномпилжээ	Чингэлтэй дүүргийн 12 дугаар хорооны иргэн	РП61090503
12.	Д.Оюумаа	Чингэлтэй дүүргийн Ардчилсан намын улс төрийн ажилтан	ГЮ63021966
13.	М.Сумьяа	Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны иргэн	ЛЮ59042809
14.	М.Очирбат	Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны ахмадын зөвлөлийн дарга	ЭА39021576
15.	Ц.Лхагважав	Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хорооны ахмад настан	ЧТ42030879

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 02 сарын 09-ний
өдрийн 18 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



“Хүндэт өргөмжлөл”-өөр шагнагдах хүмүүсийн нэрс

Д/д	Овог нэрс	Эрхэлсэн ажил, мэргэжил	Регистрийн дугаар
1.	Д.Ган-Очир	Түвдэнпэлжээлин хийдийн Унзад лам	ЛК77010317
2.	Б.Галсайхан	Түвдэнпэлжээлин хийдийн Хурлын лам	ИА80013112
3.	П.Энхжаргал	Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны Халамжийн мэргэжилтэн	ХЕ83050261
4.	Д.Эрдэнэчимэг	Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны иргэн	ХП48112966
5.	Б.Гансайхан	Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны иргэн	ЧМ62071166
6.	С.Баттөмөр	Чингэлтэй дүүргийн 8 дугаар хорооны иргэн	ЕЛ59040612
7.	П.Оюун	Чингэлтэй дүүргийн 11 дүгээр хорооны иргэн	ХИ63032867
8.	Д.Энхтуяа	Чингэлтэй дүүргийн 12 дугаар хорооны иргэн	СЮ71070664
9.	Т.Янжмаа	Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны ахмад настан	УС53080520
10.	Д.Цэндсүрэн	“Перпкал” ХХК-ийн жижүүр	ХМ60082400
11.	Д.Нарангэрэл	“Албан халбага” ХХК-ийн худалдагч	ХН63010901
12.	Б.Батцэцэг	Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны иргэн	Х374112904
13.	П.Эрдэнэчимэг	Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны ахмад настан	ТЯ55081707
14.	Г.Түмэнбаяр	Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны зохион байгуулагч	ЧЕ81100717
15.	Ц.Борхүү	Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хорооны хэв журмын урамшилт эргүүл	ФМ50011810
16.	Б.Дарьжав	Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хорооны иргэн	ХВ58070500



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

Шагналд уламжлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улсад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа зарим хүмүүсийн хөдөлмөр бүтээлийг үнэлж, Төрийн дээд шагнал, цол, одон медалиар шагнуулахаар тодорхойлсон байгууллага, хамт олны саналыг дэмжиж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд уламжилсугай. Үүнд:

МОНГОЛ УЛСЫН “ГАВЪЯАТ ДАСГАЛЖУУЛАГЧ ЦОЛ”-ООР:

1. Янжингийн Баатар Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны ахмад настан

МОНГОЛ УЛСЫН “ГАВЪЯАТ БАГШ ЦОЛ”-ООР:

1. Санжаадоржийн Дашмаа Чингэлтэй дүүргийн 39 дүгээр цэцэрлэгийн Арга зүйч

“АЛТАН ГАДАС ОДОН”-ООР:

1. Дагвасамбуугийн Ханд Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны ахмад настан

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ